



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/494

Улаанбаатар хот


Комисс шинэчлэн томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 8.3.1 дэх заалт, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар баталсан "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар"-ын 2.2.2, 2.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 151 дүгээр тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан тус байгууллагын архивын баримт бичиг нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Захиргаа, удирдлагын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Захиргаа, удирдлагын газрын архивын арга зүйч мэргэжилтэн
Гишүүд:	Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн мэргэжилтэн Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны дарга Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын нягтлан бодогч Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Нисэх буудлуудын удирдах газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт, стандарт хариуцсан мэргэжилтэн Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны захиргааны мэргэжилтэн

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны А/929 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Л.БЯМБАСҮРЭН